



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР**

/2014 ОН/



Өлгий хот 2015 он



Танилцуулгыг хянан, тохиосон:

Х.Бахыт

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Н.Манаргүл

Санал хүсэлт байвал доорх
хаягаар холбоо барина уу.

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс
Засаг даргын тамгын газрын байр

Е-mail: stat-bel@mongol.net

Утас: 70422432 ,70422322

Интернет хаяг: //www.nso.mn/bayan-ulgii/

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс
Өлгий хот, 2015 оны 3-р сар



АГУУЛГА

I. Оршил	3
I.1 Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт	4
I.2 Эдийн засагт ХАА-н салбарын эзлэх байр суурь	7
II. Мал аж ахуй	
II.2.1 Малтай өрх, малчин өрх, малчдын тоо	8
II.2.2 Малчдын соёл, ахуйн үзүүлэлт	12
II.2.3 Малын тоо	14
II.2.4 Малын сүргийн бүтэц	16
II.2.5 Малын хэрэглээний зарлага	23
II.2.6 Төл бойжилт	25
II.2.7 Том малын зүй бус хорогдол	28
II.2.8 Иргэдийн хувийн малын бүлэглэлт	31
II.2.9 Шинээр гаргасан, засварласан худгийн тайлан	32
II.2.10 Малжуулалтын талаар авсан арга хэмжээ	34
II.2.11 Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж	34
II.2.12 Тэжээвэр амьтад	36
II.2.13 ХАА-н салбарын ажиллах хүч	38
III. Газар тариалан	
III.1 Тариалсан талбай	39
III.2 Хураасан ургац	39
III.3 ХАА-н эдэлбэр газар	41
IV. Дүгнэлт	42



ОРШИЛ

ХАА-н салбар нь манай улс орны эдийн засгийн баталгаа болж байдаг. Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуйн, газар тариалангийн салбарын 2014 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогыг 2014 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, явууллаа.

Энэхүү танилцуулгад малын 2014 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна шинээр гаргасан худаг, уст цэг, малжуулалтын талаархи мэдээллийг тусган орууллаа.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар 1999 он хүртэл ДНБ-ий 30-40 орчим хувийг үйлдвэрлэж, 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч байсан бол 2014 оны хувьд өвөлжилт, хаваржилт, зуншлага сайн болж, хээлтэгч бүрээс төл хүлээн авч малын тоо толгой өнгөрсөн онтой харьцуулахад 279530 толгойгоор буюу 17.4 хувиар өссөн нь хөдөө аж ахуйн салбарын ДНБ-ний өсөлтөд нөлөөлж болно.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.



НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр – 1 бод, 1 тэмээ - 1.5 бод
6 хонь - 1 бод, 8 ямаа - 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ - 5 хонь 1 адуу - 7 хонь
1 үхэр - 6 хонь 1 хонь - 1 хонь
1 ямаа - 0.9 хонь

Богд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ – 4 настай, 5 ба түүнээс дээш настай
Адуу – 3 настай, 4 ба түүнээс дээш настай
Үхэр – 2 настай, 3 ба түүнээс дээш настай
Бог мал – тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өмнөх оны төл, 2, 3 настай, Адуу- Өмнөх оны төл, 2 настай
Үхэр- Өмнөх оны төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ. Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25, Азарга - 12-15, Бух - 35-45, Хуц, ухна - 25-30

Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол,



гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага.

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс -0.45, Таримал тэжээл -0.35, Даршны ургамал-0.25,

Гар тэжээл, хужир шүү -1.00, Төмс ногооны хаягдал -0.22,

Үр тарианы хаягдал -0.90, Лай -0.40, Сүрэл -0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
 1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
 2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
 3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай. Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай. Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээ.

Хураасан талбай. Жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээ.

Га-гийн ургац. Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.


Нийт ургац. Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

**ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ**

2014 оны эцэст тоолуулсан малын тоо 17.4 хувиар өсч хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг урьдчилсан тооцоогоор 17.8 хувь буюу 109.4 тэрбум төгрөг болж өслөө. Өнгөрсөн жилийн цаг агаарын байдлаас шалтгаалж малын тоо толгой өсөж, зүй бусаар хорогдсон малын тоо буурч, мал аж ахуйн голлох нөхөн үйлдвэрлэл бойжуулсан төлийн тоо өсөж, мөн малын үнэ болон малын арьс, шир, ноолуурын үнэ өссөн нь хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн энэхүү өсөлтөнд голлон нөлөөлсөн байна.

АЙМГИЙН ДНБ БОЛОН ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, ЭЗЛЭХ ХУВЬ

	2010	2011	2012	2013	2014	2014/2013	
						%	Зөрүү
Бүгд	108.3	143.2	179.6	225.5	251.7	111.6	26.2
ХАА-н салбар	44.9	53.4	66.9	92.9	109.4	117.8	16.5
ДНБ-д эзлэх хувь	41.5	37.3	37.2	41.2	43.5	105.5	2.3

ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ /тэрбум.төг/

Салбарын бүтцээс үзвэл анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар аймгийн ДНБ-ий 60-70 орчим хувийг үйлдвэрлэж, 2006 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-нд эзлэх хувийн жин буурч, үүний оронд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөж байна.

Улсын хэмжээнд ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь буурах хандлагатай байна. ХАА-н салбар нь 2001 онд ДНБ-ний 24.9 хувийг эзэлж байсан бол 2014 онд 14.8 хувийг эзэлж байна. Баруун бүсийн дүнд эзлэх хувь 2001-2007 онд өсөж 74.2-т хүрч 2014 онд 51.4 хувь болон бууржээ. Баян-Өлгий аймгийн хувьд хандлага нь баруун бүсийнхтэй ойролцоо байгаа бөгөөд 2004 онд 67.2 хувьд хүрч, 2014 онд 43.9 хувь болж буурлаа.



ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ



2014 ОНЫ МАЛ ТООЛЛОГЫН ДҮН

Малтай өрх малчдын тоо, тэдний соёл ахуйн үзүүлэлтүүд

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО, /сумаар/

/ 2014 он, Сумаар /

Сумын нэр	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	16-с дээш насны малчдын тоо	Үүнээс:			Нийт малчид /53/-аас эмэгтэй
				16-34 настай	35-59 эр, 35-54 эм настай	Эр 60, эм 55-с дээш	
Алтай	1 014	720	1 340	586	612	142	609
Алтанцөгц	658	382	766	305	389	72	360
Баяннуур	955	451	896	284	559	53	412
Бугат	734	466	893	367	455	71	414
Булган	1 086	729	1 414	590	752	72	618
Буянт	630	465	904	263	565	76	431
Дэлүүн	1 342	940	1 836	771	986	79	820
Ногооннуур	1 454	765	1 667	733	816	118	765
Сагсай	1 067	643	1 319	553	625	141	623
Толбо	850	629	1 252	501	636	115	579
Улаанхус	1 579	1 249	2 680	1 135	1 301	244	1 258
Цэнгэл	1 741	1 478	3 326	1 604	1 414	308	1 564
Өлгий	1 526	4	9	1	7	1	5
Дүн	14636	8921	18302	7693	9117	1492	8458

Аймгийн хэмжээгээр 2014 онд мал тооллогын дүнгээр мал бүхий 14636 өрх




тоологдсон байна. Үүний 61 хувь буюу 8921 өрх нь жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 39 хувь буюу 5715 өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх байна.

2014 онд дүнгээр 18302 малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд малчдыг насны бүлгээр авч үзвэл 42 хувь нь 16-34 настай, 49.8 хувь нь 35-59 насны, 8.1 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Сүүлийн жилүүдэд малчдын дотор 16-34 насны залуу малчдын эзлэх хувийн жин буурч, 35-аас дээш насных болон тэтгэврийн насны малчдын эзлэх хувийн жин өсөж 2014 онд 35-55 насны малчдын тоо 3.3 хувь буюу 868 хүнээр, 55-с дээш насны буюу тэтгэврийн насны малчдын тоо 0.6 хувь буюу 138 хүнээр нэмэгджээ.

2014 онд малчин өрхийн тоо 2013 онтой харьцуулахад 6.3 хувь буюу 529 өрхөөр нэмэгдлээ.


Малчин өрхийн тоо бүх сумдад нэмэгдэж, малтай өрхийн тоо Бугат суманд 20 өрхөөр, Булганд 5 өрхөөр багассан байна. Малтай өрхийн тоо сүүлийн 4 жилийн үзүүлэлтээс харахад өмнөх жилүүдэд буурсан бол сүүлийн 2 жилд өссөн байгаа нь харагдана.

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ /мян.өрх/



**МАЛТАЙ ӨРХ БОЛОН МАЛЧИН ӨРХИЙН ТОО /сумаар/**

Сумын нэр	Малтай өрхийн тоо				Малчин өрхийн тоо			
	2011	2012	2013	2014	2011	2012	2013	2014
Алтай	1020	994	989	1 014	730	721	650	720
Алтанцөгц	626	627	635	658	428	329	343	382
Баяннуур	974	937	917	955	523	498	427	451
Бугат	743	690	754	734	629	409	453	466
Булган	1088	1055	1091	1 086	783	674	721	729
Буянт	564	550	597	630	385	413	426	465
Дэлүүн	1324	1283	1306	1 342	955	800	918	940
Ногооннуур	1457	1359	1399	1 454	886	775	648	765
Сагсай	1049	1002	1044	1 067	677	616	624	643
Толбо	795	797	821	850	618	575	580	629
Улаанхус	1551	1549	1542	1 579	1129	1192	1230	1 249
Цэнгэл	1632	1590	1629	1 741	1506	1339	1370	1 478
Өлгий	1035	1087	1380	1 526	85	42	2	4
Дүн	13858	13520	14104	14636	9334	8383	8392	8921

МАЛЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР, 2014 ОН




МАЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ, ОЛОН ЖИЛЭЭР

	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007
Малтай өрх	15402	15920	15761	16298	16416	15499	15194	15126
Малчин өрх	10884	11122	11223	11200	11511	10961	11078	11102
Малчдын тоо	23310	23596	24207	23513	24889	23234	23071	23682
Үүнээс: 16-34 насны	13861	14250	14095	13805	14196	13428	13241	13114
35-аас тэтгэврийн хүртэл насны	7413	7779	8443	8035	8402	8096	8548	9140
Тэтгэврийн насны	2036	1567	1669	1673	2291	1710	1282	1428

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2014/ 2013%
Малтай өрх	14998	14930	13862	13858	13520	14104	14636	103.8
Малчин өрх	9723	10380	9436	9334	8383	8392	8921	106.3
Малчдын тоо	22886	21141	18685	18895	17808	17723	18302	103.3
Үүнээс: 16-34 насны	12377	10589	9528	9037	8644	8120	7693	94.7
35-аас тэтгэврийн хүртэл насны	8795	8189	7195	7853	7902	8249	9117	110.5
Тэтгэврийн насны	1714	2363	1962	2005	1262	1354	1492	110.2

МАЛЧДЫН ТОО, /мянга/




**Малчдын соёл, ахуйн үзүүлэлт****МАЛЧДЫН АХУЙ, СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ӨРХИЙН ТООГООР, ЖИЛЭЭР**

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Цахилгаантай өрх	5210	6250	8841	9194	9038	8947	8362	6635	7595
Телевизортой	4571	5412	7964	8935	8409	8407	8300	4745	4453
Автомашинтай	2005	2232	2604	2862	2780	2663	2693	2680	2997
Мотоциклтэй	2502	2348	2530	2437	2697	3585	3594	3187	3245
Худагтай	1158	1158	1574	1902	1198	1215	1215	2116	3029

2014 оны тооллогоор нийт малчин өрхийн 85.1 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 50 хувь нь телевизортой, 33.6 хувь нь авто машинтай, 36.4 хувь нь мотоциклтэй, 33.9 хувь нь худагтай гэсэн дүн гарлаа.

Сүүлийн жилүүдэд малчин өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг нарны зайн эрчим хүчээр хангах арга хэмжээг авч явуулсны үр дүнд цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо жилээс жилд нэмэгдсээр байна. 2006 онд 5.2 мянган өрх цахилгааны эх үүсгүүртэй байсан бол 2012 онд 8.3 мянга болж 1.6 дахин буюу 3.1 мянган өрхөөр нэмэгдсэн байна. Харин 2013 онд энэ үзүүлэлт 6.6 мянга болж 20.6 хувиар багассан нь сүүлийн жилүүдэд төврүү шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой малчин өрхийн тоо багасч улмаар цахилгааны эх үүсгүүртэй өрхийн тоо буурч байсан бол сүүлийн жилүүдэд засгийн газраас малчин өрхөд ноосны урамшуулал олгох бодлого хэрэгжүүлж байгаатай холбоотой 2014 онд малчин өрхийн тоо нэмэгдэж үүнийг дагаад цахилгаантай өрхийн тоо нэмэгдсэн байна. 2014 онд авто машинтай өрхийн тоо 317 өрхөөр, мотоциклтэй өрхийн тоо 58, худагтай өрхийн тоо 913 өрхөөр нэмэгдэж, телевизортой өрхийн тоо 292 өрхөөр буурлаа. Нийт цахилгаан үүсгүүртэй өрхийн 99.9 хувь нь нарны, үлдсэн 0.1 хувийг салхины цахилгааны эх үүсгүүртэй өрх эзэлж байна.

МАЛЧДЫН АХУЙ СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ӨРХӨӨР /мян.өрх/



МАЛЧДЫН АХУЙ, СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

/өрхийн тоогоор, 2014/

Сумын нэр	Баг хорооны тоо	Цахилгааны эх үүсгэвэртэй өрх	Үүнээс		Радиотой өрх	Оёдлын машинтай өрх	Телевизортэй өрх	Малын хашаатай өрх
			Нарны	Сапхины				
Алтай	5	402	402		140	288	243	1733
Алтанцөгц	4	361	361		336	326	305	1104
Баяннуур	5	397	397		353	356	314	2286
Бугат	4	422	422		251	200	230	902
Булган	7	677	677		319	478	503	794
Буянт	4	327	327		280	320	300	559
Дэлүүн	10	861	861		475	421	365	1313
Ногооннуур	9	694	694		290	223	226	2442
Сагсай	6	521	521		436	425	288	1129
Толбо	6	605	605		446	392	433	902
Улаанхус	8	963	963		488	466	437	2149
Цэнгэл	9	1364	1363	1	1097	918	808	2213
Өлгий	13	1	1		1	1	1	1742
Дүн	90	7595	7594	1	4912	4814	4453	19268

Сумын нэр	Худагтай өрх	Авто машинтай		Мотоциклтэй		Гар утастай		Хийсэн эсгий (м)
		Өрхийн тоо	Машины тоо	Өрхийн тоо	Мотоцикл-ийн тоо	Өрхийн тоо	Гар утасны тоо	
Алтай	121	142	158	290	292	281	324	291
Алтанцөгц	154	116	128	147	157	350	457	289
Баяннуур	676	217	244	325	329	316	332	1686
Бугат	67	230	255	180	181	201	238	290
Булган	224	247	298	385	389	367	382	317
Буянт	35	168	200	338	341	309	344	70
Дэлүүн	37	400	452	394	399	440	613	1036
Ногооннуур	728	285	366	317	319	222	232	80
Сагсай	534	284	333	205	206	393	430	934
Толбо	29	247	276	212	213	496	534	2071
Улаанхус	243	240	273	341	344	404	410	1268
Цэнгэл	159	421	1475	111	113	825	934	2350
Өлгий	22					1	1	
Дүн	3029	2997	4458	3245	3283	4605	5231	10682

**МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ**

Малын тоо. 2014 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 1883.6 мянган толгойд хүрч, өмнөх оныхоос 17.4 хувь буюу 279530 толгойгоор өслөө. Үүнд тэмээ 323 толгойгоор, адуу 11122 толгой, үхэр 22364 толгой, хонь 137034 толгой, ямаа 108687 толгойгоор тус тус нэмэгдлээ. Өнгөрсөн онтой харьцуулахад 2014 онд бүх сумдад малын тоо 10.2-23.1 хувь буюу 2430-45458 толгойгоор өссөн байна.

2014 онд нийт 49.8 мянган сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 39.1 хувийг эзэлж байна.

МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР


	2010	2011	2012	2013	2014	/толгойн тоогоор/	
						2014/2013 %	зөрүү
Бодоор /мян.тол/	261.0	302.6	326.5	377.2	446.3	118.3	69.1
Толгойн тоо	1126859	1302786	1410503	1604080	1883610	117.4	279530
Тэмээ	3766.0	3992.0	4192.0	4348.0	4671	107.4	323
Адуу	43451	48532	51705	58440	69562	119.0	11122
Үхэр	66049	80815	87198	105079	127443	121.3	22364
Хонь	459834	506911	574376	662827	799861	120.7	137034
Ямаа	553759	662536	693032	773386	882073	114.1	108687

МАЛЫН ТОО, СУМААР

	2010	2011	2012	2013	2014	2014/2013	
						%	зөрүү
Алтай	105123	110788	122834	125427	145454	116.0	20027
Алтанцөгц	40322	51472	59338	72052	87619	121.6	15567
Баяннуур	79979	97183	108243	116784	143819	123.1	27035
Бугат	50307	60706	61714	75770	86670	114.4	10900
Булган	59033	75666	81075	90810	105078	115.7	14268
Буянт	67146	74208	87501	104146	120243	115.5	16097
Дэлүүн	145026	166481	180361	207784	236491	113.8	28707
Ногооннуур	108783	123145	124189	146023	173671	118.9	27648
Сагсай	79535	90859	102663	112657	130645	116.0	17988
Толбо	85398	104146	119052	134027	159064	118.7	25037
Улаанхус	124056	135770	144615	158402	186770	117.9	28368
Цэнгэл	165730	195119	199362	236422	281880	119.2	45458
Өлгий	16421	17243	19556	23776	26206	110.2	2430
Дүн	1126859	1302786	1410503	1604080	1883610	117.4	279530



МАЛЫН ТОО



2014 онд улсын хэмжээнд нийт 51982.6 мянган толгой мал тоологдсоны 3.6 хувийг манай аймаг эзэлж байна. Үүнээс, тэмээ 1.3 хувь, адуу 2.3 хувь, үхэр 3.7 хувь, хонь 3.4 хувь, ямаа 4.0 хувийг тус тус эзэлнэ.

МАЛЫН ТОО, УЛСЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ

	/мян.тол/								
	Малын тоо /Аймгийн дүнгээр/			Малын тоо /Улсын дүнгээр/			Улсын дүнд эзлэх %		
	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014
Бодоор	326.5	377.2	446.3	10592.2	11685.4	13553.8	3.1	3.2	3.3
Толгойн тоо	1410.5	1604.0	1883.6	40920.9	45144.4	51982.7	3.4	3.6	3.6
Тэмээ	4.2	4.3	4.7	305.8	321.5	349.3	1.4	1.3	1.3
Адуу	51.7	58.4	69.6	2330.4	2619.4	2995.8	2.2	2.2	2.3
Үхэр	87.2	105.1	127.4	2584.6	2909.5	3413.9	3.4	3.6	3.7
Хонь	574.4	662.8	799.8	18141.4	20066.4	23214.8	3.2	3.3	3.4
Ямаа	693.0	773.4	882.1	17558.7	19227.6	22008.9	3.9	4.0	4.0

ИРГЭДИЙН ХУВИЙН МАЛЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

	1990	1995	2000	2008	2009	2010	2011
Малтай өрхийн тоо	13465	14456	15402	14998	14930	13862	13858
Бодоор	220439	365950	340924	344469	293285	253951	293760
Толгойн тоо	607645	1255345	1299891	1523058	1296751	1122835	1298851
Тэмээ	5012	8445	6943	3943	3863	3764	3989
Адуу	58812	78561	67905	59091	50453	43077	48160
Үхэр	84156	118199	95975	82163	70671	66019	80785
Хонь	299884	606131	611910	601633	521362	457245	504472
Ямаа	159781	444009	517158	776228	650402	552730	661445




	2012	2013	2014	2014/1990		2014/2013	
				%	Өсөлт(-,+)	%	Өсөлт(-,+)
Малтай өрхийн тоо	13520	14104	14636	108.7	1171	103.8	532
Бодоор	326556	376132	446352	202.5	225913	118.7	70220
Толгойн тоо	1406887	1600067	1878450	309.1	1270805	117.4	278383
Тэмээ	4190	4346	4669	93.2	-343	107.4	323
Адуу	51326	57976	68863	117.1	10051	118.8	10887
Үхэр	87154	105023	127306	151.3	43150	121.2	22283
Хонь	572086	660576	796869	265.7	496985	120.6	136293
Ямаа	692131	772146	880743	551.2	720962	114.1	108597

МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, ХУВИАР

	2009	2010	2011	2012	2013	2014
Тэмээ	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.2
Адуу	3.9	3.9	3.7	3.7	3.6	3.7
Үхэр	5.4	5.9	6.2	6.2	6.6	6.8
Хонь	40.4	40.8	38.9	40.7	41.3	42.5
Ямаа	50.0	49.1	50.9	49.1	48.2	46.8
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

2014 оны малын тоо толгойн өсөлт нь үндсэндээ бог малын өсөлтөөр хангагдсан бөгөөд нийт өсөлтийн 49 хувийг хонь, 38.9 хувийг ямаа, 8 хувийг үхэр, 4 хувийг адууны өсөлт хангасан байна.

МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, ХУВИАР






Нийт сүргийн 1979 онд 27.6 хувийг ямаа, 58.5 хувийг хонь, 7.1 хувийг үхэр, 5.7 хувийг адуу, 1.1 хувийг тэмээ эзэлж байсан бол 2014 онд 46.8 хувийг ямаа, 42.5 хувийг хонь, 6.8 хувийг үхэр, 3.7 хувийг адуу, 0.2 хувийг тэмээ эзэлж байна.

Сүргийн бүтцэд 1971-2014 онд ямааны эзлэх хувь 19.2 пунктээр өсч, харин хонины эзлэх хувь 16 пункт, үхрийх 0.3 пункт, адууных 2 пункт, тэмээ 0.9 пунктээр буурсан байна.

Улсын хэмжээнд нийт сүрэгт эзлэх хонины тоо толгойн хэмжээ буурах хандлагатай байна. Баян-Өлгий аймгийн нийт мал сүргийн 1991 онд 60.7 хувийг хонь эзэлж байсан бол 1992 оноос буурч 2014 онд 42.5 хувьд хүрчээ. Аймгийн хонины тоо толгойн нийт сүрэгт эзлэх хувь 2001-2014 онд улсын болон баруун бүсийн дүнгээс доогуур түвшинд байна.

ХОНИНЫ ТОО ТОЛГОЙН НИЙТ СҮРЭГТ ЭЗЛЭХ ХУВЬ




Улсын хэмжээнд нийт сүрэгт эзлэх ямааны тоо толгойн хэмжээ 1971-1992 онд тогтвортой байсан бол 1992 оноос огцом өсөх хандлагатай байна. Баян-Өлгий аймгийн нийт сүргийн 1971 онд 26.3 хувийг ямаа эзэлж байсан бол 2014 онд 46.8 хувьд хүрчээ. Ямааны тоо толгойн нийт сүрэгт эзлэх хувь улсын дүнгээс 4.5 пунктээр өндөр байгаа ч баруун бүсийн дүнгээс 1.5 пунктээр бага байна.

Аймгийн малын тооны олон жилийн динамикийг харахад түүний өөрчлөлтөд нийгмийн өөрчлөлтөөс гадна цаг агаарын хүчин зүйл хүчтэй нөлөөлж байна. 1990-ээд оны эхээр мал хувьчилсны дараа малын тооны тодорхой өсөлт гарсан боловч 2001, 2002, 2010 оны өвөл, хаврын зуд малын тоог ихээхэн бууруулсан билээ. Энэ хандлага бүх төрлийн малд ажиглагдсан бөгөөд зудны дараа түргэн өсөлттэй ямаа, хонь хурдан өссөн байна. Ноолуурын үнийн өсөлтөөс шалтгаалан ямаагаа түлхүү өсгөх хандлагатай байна.



ЯМААНЫ ТОО ТОЛГОЙН НИЙТ СҮРЭГТ ЭЗЛЭХ ХУВЬ



ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

	1990	1995	2000	2003	2004	2005	2006	2007
Дүн	610244	523087	596729	579504	584869	585170	637726	681498
Ингэ	2749	1037	2102	1544	1430	1061	1074	1075
Гүү	21685	17859	23145	18467	18455	17213	18356	18909
Үнээ	45051	37530	46458	37088	37417	34016	36785	38853
Эм хонь	398136	291993	291630	259297	252584	251504	271093	283481
Эм ямаа	142623	174668	233394	263108	274983	281376	310418	339180

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2014/2013 %
Дүн	664758	602941	519337	566233	626572	685412	797053	116.3
Ингэ	1034	1019	1084	1181	1279	1333	1453	109.0
Гүү	17335	16172	13788	14716	15573	17305	20594	119.0
Үнээ	34579	31193	30544	34998	38083	43803	51023	116.5
Эм хонь	269837	243500	213163	226635	260038	291846	349634	119.8
Эх ямаа	341973	311057	260758	288703	311599	331125	374349	113.1

Хээлтэгч мал нь нийт малын 42.3 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 31.1 хувь, адуун сүргийн 29.6 хувь, үхэр сүргийн 40 хувь, хонин сүргийн 43.7 хувь, ямаан сүргийн 42.4 хувийг тус тус эзэлж байна.



Мал аж ахуйн эрдэмтэн судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад хээлтэгч мал бод малын хувьд сүргийн 50 – 55 хувь, бог малын хувьд сүргийн 60 – 65 хувийг эзэлж байвал зохимжтой байна гэж үздэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ харьцаа алдагдаж, сүүлийн 5 жилийн байдлаар хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 36.5 хувь, бог малд 47.1 хувь байна.

НИЙТ МАЛЫН ТООНД ХЭЭЛТЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

	2010	2011	2012	2013	2014	2014/2013	
						%	Зөрүү
Дүн	50.2	48.1	48.6	42.7	42.3	99.0	-0.4
Ингэ	31.4	32.0	31.8	30.7	31.1	101.5	0.4
Гүү	33.9	32.1	33.5	29.6	29.6	100.0	0.0
Үнээ	53.0	47.1	50.2	41.7	40.0	96.0	-1.6
Эм хонь	49.3	51.3	50.8	44.0	43.7	99.3	-0.3
Эх ямаа	52.1	47.0	47.8	42.8	42.4	99.1	-0.4

ТӨЛ ӨГӨӨГҮЙ ХЭЭЛТЭГЧ

Сумын нэр	2013	2014	Ү ү н э э с					Оны эхний хэвлэгчид хээлтэгчид эзлэх %	өмнөх оноос зөрүү /-,+/ %
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа		
Алтай	2606	655		108	116	165	266	4.8	-1951
Алтанцөгц	1821	801		89	134	167	411	6.7	-1020
Баяннуур	980	3218	1	130	226	586	2275	1.9	2238
Бугат	6337	646	3	68	77	176	322	22.7	-5691
Булган	924	3568	19	262	350	731	2206	2.6	2644
Буянт	3420	299	2	91	78	61	67	8.8	-3121
Дэлүүн	724	1082	6	111	157	320	488	0.9	358
Ногооннуур	4297	595	8	46	93	228	220	8.3	-3702
Сагсай	1805	328	1	38	48	111	130	3.9	-1477
Толбо	904	610	1	22	64	248	275	1.8	-294
Улаанхус	1522	926	8	82	130	304	402	2.4	-596
Цэнгэл	2365	1166	2	43	108	312	701	2.7	-1199
Өлгий	1863	1895		72	403	547	873	18.8	32
Дүн	29568	15789	51	1162	1984	3956	8636	4.7	-13779

**ХЭЭЛ ХАЯСАН ХЭЭЛТЭГЧ**

	1990	1995	2000	2003	2004	2005	2006	2007
Дүн	20649	5287	52085	12857	16609	70210	15000	35586
Ингэ	47	23	15	12	47	26	4	20
Гүү	2269	703	5569	1524	1972	3428	1294	2046
Үнээ	1701	822	5859	1739	2207	4242	1263	2472
Эм хонь	9158	1891	11785	3643	3913	11122	4134	9041
Эм ямаа	7474	1848	28857	5939	8470	51392	8305	22007

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	<u>2014/2013</u> %
Дүн	105416	90454	105922	7876	59246	13636	6061	44.4
Ингэ	9	24	40	3	2	6	7	116.7
Гүү	5459	3046	3669	557	362	290	217	74.8
Үнээ	6499	2282	2514	428	5126	505	245	48.5
Эм хонь	17446	8463	11392	1047	7046	2876	1193	41.5
Эм ямаа	76003	76639	88307	5841	46710	9959	4399	44.2

2014 онд оны эхний төллөх насны хээлтэгчийн 0.9 хувь буюу 6061 толгой мал хээл хаясаны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаясан малын тоо 2013 оныхоос 7575 толгойгоор буюу 2.2 дахин буурлаа.

Төл өгөөгүй нийт хээлтэгчийн 38.4 хувь буюу 6061 нь хээл хаясан хээлтэгч, 61.6 хувь буюу 9728 нь сувайрсан хээлтэгч байна.

Сувайрсан малын тоо 2013 оныхоос 38.9 хувь буюу 6204 толгойгоор буурав.

СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ

	1990	1995	2000	2003	2004	2005	2006	2007
Дүн	19699	7807	22376	13179	15463	26113	13943	13943
Ингэ	1444	41	220	11	25	19	17	17
Гүү	5058	1203	3421	1559	2805	2138	1480	1480
Үнээ	6085	1777	4742	2750	3175	3698	2429	2429
Эм хонь	4384	3014	6896	3492	4434	9425	4155	4155
Эм ямаа	2728	1772	7097	5367	5024	10833	5862	5862



	2008	2009	2010	2011	2012	2013	2014	<u>2014/2013</u> %
Дүн	24603	30953	48167	11876	19683	15932	9728	61.1
Ингэ	17	3	16	14	17	39	44	112.8
Гүү	1908	2086	2493	1181	1990	1392	945	67.9
Үнээ	4036	3820	4568	2234	2424	2629	1739	66.1
Эм хонь	7317	9097	20293	4027	6644	4996	2763	55.3
Эм ямаа	11325	15947	20797	4420	8608	6876	4237	61.6

ХЭЭЛ ХАЯСАН, СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ /мян.тол/



ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО

	1995	2000	2011	2012	2013	2014	<u>2014</u> <u>2013%</u>
Буур	96	67	76	105	86	75	87.2
Азарга	2617	2429	1551	1566	1677	1876	111.9
Бух	3651	2134	1952	1923	2192	2298	104.8
Хуц	7721	6784	5481	6017	6610	7243	109.6
Ухна	5716	5986	7242	7320	7566	8143	107.6
Дүн	19801	17400	16302	16931	18131	19635	108.3

2014 онд 19635 толгой хээлтүүлэгч мал тоологдож 2013 оныхоос 8.3 хувь буюу 1504 толгойгоор нэмэгдэв.



НЭГ ХЭЭЛТҮҮЛЭГЧИД НООГДОХ ХЭЭЛТЭГЧИЙН ТОО

	үржлийн норм	2010	2011	2012	2013	2014	$\frac{2014}{2013}$ %
Ингэ	20-25	17	16	12	16	19	118.8
Гүү	12-15	11	10	10	10	11	110.0
Үнээ	35-45	22	18	20	20	22	110.0
Эм хонь	25-30	42	41	43	44	48	109.1
Эм ямаа	25-30	45	40	43	44	46	104.5

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд үржлийн нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой атал 48 эм хонь, 46 эм ямаа ногдож 60 хувиар өндөр үзүүлэлт гарч байна.

СҮРГИЙН БҮТЭЦ

	Мянган толгойгоор			Хувиар			Толгой 2014/2013
	2012	2013	2014	2012	2013	2014	
Бүгд	1410.5	1604.1	1883.6	100.0	100.0	100.0	279.5
Өсвөр насны төл	500.5	607.3	664.4	35.6	37.9	35.3	57.1
Ажлын ба бэлтгэл насны	266.6	293.3	402.5	18.9	18.3	21.4	109.2
Хээлтэгч	626.5	685.4	797.1	44.3	42.7	42.3	111.7
Хээлтүүлэгч	16.9	18.1	19.6	1.2	1.1	1.0	1.5

МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, 2014 ОН, СУМААР


Сумын нэр	Бүгд хувиар	Өсвөр насны төл	Ажлын ба бэлтгэл насны	Хээлтэгч	хээлтүүлэгч
Алтай	100.0	37.4	16.6	44.7	1.2
Алтанцөгц	100.0	35.1	20.3	43.7	0.9
Баяннуур	100.0	31.2	26.5	41.1	1.2
Бугат	100.0	36.6	19.1	43.2	1.1
Булган	100.0	35.6	21.1	42.3	1.0
Буянт	100.0	37.1	18.1	43.7	1.2
Дэлүүн	100.0	37.7	19.4	42.0	0.9
Ногооннуур	100.0	33.8	24.2	41.1	1.0
Сагсай	100.0	37.7	16.9	44.4	1.0
Толбо	100.0	33.4	25.9	39.5	1.1
Улаанхус	100.0	35.9	19.6	43.6	0.9
Цэнгэл	100.0	33.5	24.5	40.9	1.1
Өлгий	100.0	33.8	18.8	47.2	0.2
Дүн	100.0	35.3	21.4	42.3	1.0



2014 оны байдлаар нийт малын 35.3 хувь буюу 664.4 мянган толгой нь төл өсвөр насны мал, 21.4 хувь буюу 402.5 мянган толгой нь нас гүйцсэн ажлын ба бэлтгэл насны мал, 42.3 хувь буюу 797.1 мянган толгой нь хээлтэгч мал, 1 хувь буюу 19.6 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна. 2014 онд нийт малын тоонд төл өсвөр насны малын эзлэх хувийн жин өмнөх оныхоос 2.6 пунктээр, хээлтэгчийн хувийн жин 0.4 хувь, хээлтүүлэгчийн эзлэх хувийн жин 0.1 пунктээр тус тус буурч, ажлын ба бэлтгэл насны малын эзлэх хувийн жин 3.1 пунктээр нэмэгдсэн байна.

Малын хэрэглээний зарлага

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГЫН БҮТЭЦ /хувиар/



2014 онд оны эхний малын 17.9 хувьтай тэнцэх 287404 толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. 2013 оныхоос 14.5 мянган толгой буюу 5.3 хувиар нэмэгдсэн байна. Малтай нэг өрх дундажаар 19 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан бол аймгийн хэмжээний нийт өрхөд харьцуулбал нэг өрх дундажаар 13 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

Хэрэглээндээ зарцуулсан нийт малын 0.1 хувийг тэмээ, 2.1 хувийг адуу, 5.3 хувийг үхэр, 42.3 хувийг хонь, 50.1 хувийг ямаа эзэлнэ.

Хэрэглээнд зарцуулсан малын 92.4 хувийг бог мал, 7.6 хувийг бод мал эзэлнэ. Сумаар авч үзвэл хэрэглээндээ хамгийн их мал зарцуулсан Цэнгэл сум 44.9 мянган толгой, Улаанхус 34.8 мянган толгой, Дэлүүн 31.1, Ногооннуур 30.3 мянган толгойг тус тус зарцуулсан байна.

**МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА**

Сумын нэр	2013	2014	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Алтай	2370	22366	21	669	1412	11437	8827
Алтанцөгц	23550	13225	18	163	408	4397	8239
Баяннуур	10033	16513	27	395	559	5433	10099
Бугат	16012	14006	3	314	588	5875	7226
Булган	13258	17064	39	410	1571	4859	10185
Буянт	16307	17273	10	245	951	9647	6420
Дэлүүн	15257	31073	27	760	1637	12487	16162
Ногооннуур	32503	30309	29	574	1146	10334	18226
Сагсай	24304	16887	10	441	832	8208	7396
Толбо	17184	25988	9	357	957	12822	11843
Улаанхус	23951	34837	72	725	2265	16565	15210
Цэнгэл	33809	44907	59	913	2492	18598	22845
Өлгий	44377	2956	2	40	554	929	1431
Дүн	272915	287404	326	6006	15372	121591	144109


Сумын нэр	Оны эхний малд эзлэх хувь						2014- 2013
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	зөрүү
Алтай	17.8	5.9	10.1	12.3	19.0	18.9	19996
Алтанцөгц	18.4	4.0	6.7	11.7	19.0	19.4	-10325
Баяннуур	14.1	6.0	10.4	11.7	16.0	13.7	6480
Бугат	18.5	10.3	12.7	13.7	19.7	18.4	-2006
Булган	18.8	7.3	9.4	19.3	22.1	18.2	3806
Буянт	16.6	6.1	8.0	13.4	16.3	18.5	966
Дэлүүн	15.0	10.1	9.3	11.4	15.6	15.4	15816
Ногооннуур	20.8	8.6	11.3	15.8	21.9	21.2	-2194
Сагсай	15.0	3.5	9.1	11.5	15.5	15.6	-7417
Толбо	19.4	11.4	10.1	13.2	18.1	22.6	8804
Улаанхус	22.0	10.5	13.3	19.5	22.0	23.2	10886
Цэнгэл	19.0	9.2	11.6	18.8	18.2	20.4	11098
Өлгий	12.4	2.7	5.5	11.4	15.6	11.8	-41421
Дүн	17.9	7.5	10.3	14.6	18.3	18.6	14489




Төл бойжилт

2014 оны байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 98.6 хувь буюу 675824 толгой эх мал төллөж гарсан төлийн 98.3 хувь буюу 664384 төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2013 оныхоос 57112 толгой буюу 9.4 хувиар нэмэгдлээ.

БОЙЖУУЛСАН ТӨЛ, СУМААР, 2014 ОН /мян.тол/



БОЙЖУУЛСАН ТӨЛ, ОЛОН ЖИЛЭЭР /мян.тол/



**БОЙЖУУЛСАН ТӨЛ, ОЛОН ЖИЛЭЭР**

Он	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
1990	517616	1050	12040	33989	350970	119567
1995	497763	771	15210	33553	281715	166514
1997	532687	862	16167	38279	288883	188496
1998	390894	638	9988	29507	217656	133105
1999	528661	818	14510	36919	281421	194993
2000	432093	619	10377	30271	232228	158598
2001	464662	624	12163	28100	238312	185463
2002	336929	567	8420	23093	178912	125937
2003	515438	613	12776	29938	236176	235935
2004	524505	547	11917	29467	232859	249715
2005	410257	473	9664	24541	203799	171780
2006	521900	508	12240	28166	231710	249076
2007	539265	443	12402	28270	240525	257625
2008	484506	424	9729	23705	234999	215649
2009	413901	487	8656	22460	207360	174938
2010	357520	420	6726	19061	181318	149995
2011	487580	615	11036	26655	204194	245080
